

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага

Албан тушаалтны нэр:

Телекамерын жижүүрийн цагдаа

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго:

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж, орчин үеийн техник технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд дуу дүрсний болон бусад хяналтын системээр хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

Албан тушаалын зорилт:

1.Хууль тогтоомж, холбогдох бусад эрхийн актын хэрэгжилтийг хангах, Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцож, удирдлагад танилцуулах.

2.Гудамж, зам талбайд суурилуулсан хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг байнга хийлгэж, хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагаандаа ашиглах, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг камерын хяналтад авч, гэмт хэрэг, зөрчлийг камерын хяналтаар илрүүлэх.

3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш |
|---------------------------|--|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <p>1.1. Монгол Улсын хууль тогтоомжууд, Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан журам, зааврууд, дэвшүүлсэн зорилт, удирдлагын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</p> <p>1.2. Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтан удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмж, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цагдаагийн бусад алба хаагч, нэгжтэй хамтран ажиллах.</p> | <p>Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилт хангагдана. Улаанбаатар хот, төв, суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөл сайжирна.</p> | <p>Г</p> <p>Т, Г</p> |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>2.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд камерын хяналтаар гэмт хэрэг, зөрчил илрүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;</p> <p>2.2. Нийт камеруудад үзлэг, тооллого хийж ашиглалт, техникийн байдлыг шалгаж, холбогдох тооцоо судалгааг гарган танилцуулах;</p> <p>2.3. Хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжүүдийн сүлжээ, дэд бүтцийн засвар үйлчилгээг хийлгэх ажилд хяналт тавих;</p> <p>2.4. Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой мэдээлэл, бичлэгийг файл үүсгэн компьютер болон төхөөрөмжид хадгалах, хяналтын камер, системийн техник хэрэгсэл, тоног, төхөөрөмжийн ажиллагааны байдалд хяналт тавьж, гарсан гэмтэл, саатлын талаар жижүүрийн ахлах мөрдөгч болон хариуцсан инженерт мэдэгдэж бүртгэн, шуурхай засварлуулах.</p> <p>2.5. Шаардлагатай гудамж, зам, талбай, объект цэгийг камержуулах, байршлыг өөрчлөх санал боловсруулж өгөх;</p> <p>2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийг камержуулах ажилд татан оролцуулах;</p> <p>2.7. Холбогдох бүртгэл, судалгааг хөтлөх;</p> | <p>Нийтийн хэв журам хамгаалах нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдана. Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> | <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> |

| | | | |
|---------------------------|---|--|----------------------------|
| | <p>2.8.Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, байгалийн гамшиг, хүн, малын гоц халдварт өвчин үүссэн, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг сахиулах, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах;</p> <p>2.9.Иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр камерын бичлэгийг шүүж хойшлуулшгүй ажиллагаа явуулж лавлагаа гарган өгч, бүртгэл тэмдэглэл хөтлөх.</p> | | Г |
| | | | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <p>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</p> <p>1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p> | <p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.</p> | Г Г Г Г Г Г |

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА


| | | |
|------------------|---|--|
| Боловсрол | Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролийн зэрэгтэй. | |
| Мэргэжил | | |
| Мэргэшил | Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх | |
| Туршлага | | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах. -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах. |

| | |
|--------------------|---|
| Асуудал шийдвэрлэх | - Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог. -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг. |
| Багаар Ажиллах | - Өөрийн мэдлэг ур чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх. |
| Бусад | |

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|--|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга | |
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо | Бусад харилцах субъект: Шууд харилцах: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан. Шууд бус харилцах: Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/. |

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|--|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны 12 дугаар сарын 27 ны өдөр | Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:..... |

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

| | |
|--|---|
| Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр. Дугаар: 1/но1 |  Т.СҮХБОЛД 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр |
|--|---|

Танилцсан:

| |
|--|
| Танилцсан албан тушаалтан: |
| 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр |